



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 1/04

Биндэр сум

Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 78 дугаар зүйлийн 78.1.3. дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын олон нийтийн цагдаа Төмөрбаатарын Наранчимэгийг 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр хөдөлмөрийн гэрээг цуцалж, үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Т.Наранчимэгийн ажилласан хугацааны ээлжийн амралтын тооцоог хийж санхүүгийн тооцоог дуусгахыг нягтлан бодогч (Г.Амгаланцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3.Т.Наранчимэгийн ажил хүлээлцэх комиссыг доор дурьдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Комиссын даргаар: Г.Амгаланцэцэг /Нягтлан бодогч/

Гишүүнээр: - Х.Анужин /Архив бичиг хэргийн эрхлэгч/

- Д.Сарангэрэл /Аж ахуйн эрхлэгч/

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

